



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 9/536

Мандалговь

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 45 дугаар зүйлийн 45.6, 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2018 онд Аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр батлагдсан "Өндөршил сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний ажлын эрхийг Өндөршил сумын Засаг даргад шилжүүлсүгэй.

Хоёр. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг гүйцэтгэгчтэй хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулж, ажлыг чанартай гүйцэтгүүлэн, үе шатны ажилд тавих хяналтыг хариуцлагатай зохион байгуулж ажиллахыг Өндөршил сумын Засаг дарга (Л.Мөнхбадрах)-д үүрэг болгосугай.

Гурав. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах тухай хуулийн 46.3 дахь заалтыг үндэслэн эрх шилжүүлэн гүйцэтгүүлж байгаа хөрөнгө оруулалт, ажлын гүйцэтгэлд байнгын хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир)-т, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж)-т, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010657

